



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 14 өдөр

Дугаар А/393

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “н” заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтийг хангуулах, байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдлагуудын хамтран баталсан “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Н.Бямбажав - Аймгийн Цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Гишүүд:

П.Эрдэнэчулуун - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Л.Батбаяр - Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Сумдын Засаг дарга нар

Сумдын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар

Нарийн бичгийн

дарга: Ё.Дамдин - Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад

2.Тус арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, нөхөн сэргээлт хийсэн талбайд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг явуулж, авсан арга хэмжээний үр дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Н.Бямбажав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02 01693